



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ УВС АЙМГИЙН ТАЙЛАН-2016



Статистикийн хэлтэс

Улаангом

## БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2016 ОН

ҮСХ-ны даргын 2013 оны 11 сарын 26 ны өдрийн 134 –р тушаалаар батлагдсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал”-ын албан бус секторын үйлдвэрлэлийн тооцооны арга зүй хэсэгт албан бус салбарын суурь судалгааг 5 жил тутам явуулна гэж заасан билээ. Уул уурхайн салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлт буюу бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид нь далд эдийн засгийн нэг хэсэг болно. Энэхүү аргачлалын хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр уул уурхайн салбарт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгааг 2 дахь удаагаа амжилттай зохион байгуулсан.

**Судалгааны зорилго:** Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүдийн хамрах хүрээг тогтоож бүртгэх, тэдгээрийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлж, ДНБ-ний тооцоонд тусгах, бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангах өмнөх судалгааны мэдээлэлд харьцуулалт хийх, шаардлагатай нэмэлт үзүүлэлтийг бий болгоход чиглэгдсэн.

**Тодорхойлолт:** Бичил уурхайн үйл ажиллагаа гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлохыг хэлнэ.

**Судалгааны зохион байгуулалт:** Бичил уурхайн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар оролцдог бүртгэгдсэн, бүртгэгдээгүй нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг хамруулсан.

Судалгаа 2 шаттайгаар явагдсан. Нэгдүгээр шатны судалгааг 2016 оны 10 сарын 10 наас 2 сарын хугацаанд, хоёрдугаар шатны нэмэлт судалгааг 2017 оны 4 сард зохион байгуулсан. Манай аймгийн Тэс, Хяргас, Түргэн, Тариалан, Өмнөговь сумын нутагт орших орд газруудад бичил уурхай эрхэлж байсан иргэдийг хамруулж мэдээллийг цуглуулсан. Судлаач нар сонгогдсон сумынхаа ашигт малтмалын илрэл бүхий орд, газруудад биечлэн очиж бичил уурхай эрхлэгчдээс асуулгын дагуу судалгааг авсан бөгөөд судалгаа явагдах үеэр бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг аль болох бүрэн хамруулах зорилгоор судлаач нар олон удаагийн давтамжтайгаар орд газруудад очиж, мэдээллийг цуглуулсан. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг боловч судалгаа явагдах хугацаанд тухайн орд газарт ажиллаагүй иргэдийг орхигдуулахгүйн тулд сум, багийн анхан шатны бүртгэлд тулгуурлан тулгалтыг хийж судалгаанд хамруулав.

Энэ удаагийн судалгааны асуулгад бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага зэрэг тэдний өнөөгийн дүр төрхийг харуулж чадахуйц 10 бүлэг, 106 үндсэн үзүүлэлтийг багтаасан.

Бүлэг 1. Хаягийн хэсэг: Бичил уурхай эрхлэгчдийн байршлын мэдээллийг аймаг, сум, баг, ашигт малтмалын орд газрын түвшинд цуглуулахуйц 8 асуулт

Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл: Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн нас, хүйс, боловсрол, мэргэжил, ам бүл зэрэг ерөнхий мэдээллийг агуулсан 9 асуулт

Бүлэг 3. Ажил эрхлэлт БУ эрхэлж буй хугацаа, сууцны нөхцөл, цахилгаан, усны эх үүсвэр зэрэг ажил эрхлэлтийн мэдээллийг агуулсан 17 асуулт

Бүлэг 4. Хүүхдийн эрх: Бичил уурхайд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, оролцож буй хэлбэр, бэртэл гэмтлийн талаарх 10 асуулт

Бүлэг 5. Мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл авах суваг: Бичил уурхайн эрхлэгчдийн мэдээлэл хүлээн авдаг эх үүсвэр, интернет гар утасны хэрэглээ зэрэг үзүүлэлтүүдийн талаарх 4 асуулт

Бүлэг 6 . Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээлэл

Бичил уурхай эрхлэгчдийн бэртэл, гэмтэл, өвчлөлт, эмнэлгийн тусламж авах боломжийн талаарх 8 асуулт

Бүлэг 7. Нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр: БУ эрхлэгчдийн хамрагдсан даатгал, түүний төрөл, өөрсдийн амьжиргаанд орсон өөрчлөлт болон орон нутагт оруулсан хувь нэмэр зэрэг 8 асуулт

Бүлэг 8. Тусламж, дэмжлэг, тулгарч буй хүндрэл, бэрхшээл: БУ эрхлэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх 16 асуулт

Бүлэг 9. Тоног төхөөрөмж: БУ-н үйл ажиллагаандаа ашигладаг тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэхийг багтаасан 5 асуулт

Бүлэг 10. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл: БУ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас олсон орлого, зарцуулсан зардал, төлсөн татвар, хураамж зэрэг эдийн засгийн холбогдолтой үзүүлэлтийг багтаасан 21 асуултаас бүрдэнэ.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн хэмжээнд бичил уурхай эрхэлж байгаа 539 иргэн судалгаанд хамрагдаж 172 иргэн нь судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн гишүүн буюу бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 21 хувь нь эмэгтэй иргэд байв. Өмнөх судалгаанд 1705 иргэн хамрагдсаны 653 нь эмэгтэй иргэд байлаа.

*Өмнөх судалгаанд оролцогчдын 18.1 хувь нь сургуулийн насны хүүхдүүд байсан бол энэ удаагийн судалгаанд сургуулийн насны 1 хүүхэд хамрагдсан нь судалгаа явагдсан хугацаа өөр байсныг харуулж байна.*


Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч судалгаанд хамрагдсан иргэдийг засаг захиргааны харъяаллаар авч үзвэл Архангайн 3, Завханы 2, Ховдын 1, Дарханы 1, Орхоны 1 бусад буюу 530 нь өөрийн орон нутгийн харъяат иргэд байлаа.

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 15-17 насны 1, 18-19 насны 13, 20-24 насны 54, 25-29 насны 71, 30-34 насны 67, 35-39 насны 77, 40-44 насны 113, 45-49 насны 81, 50-54 насны 42, 55-59 насны 16, 60-64 насны 4 иргэд байна.

Эндээс харахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын дийлэнх нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 20-54 насных байгаа нь орон нутагт байнгын ажлын байр хомс байгааг харуулж байна.

Өмнөх судалгаанд оролцогчдын 18.1 хувь нь 10-17 насны хүүхэд, 80.4 хувь 20-54 насны үлдэх хувь нь 55-аас дээш насны иргэд байлаа.

Зураг 1. Судалгаанд оролцогчид насны бүлгээр



Хүн амын хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд нь боловсролын түвшингээс ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл хүн амын амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэх нэг чухал үзүүлэлт нь боловсролын асуудал гэж үзэж болно.

Судалгаанд оролцогчдын 18 буюу 3.3 % нь боловсролгүй, 83 буюу 15.4 % нь бага, 185 буюу 34.3% нь суурь, 181 буюу 33.6 % нь бүрэн дунд, 49 буюу 9.1 % техникийн болон тусгай мэргэжлийн , 23 буюу 4.3 % нь дээд боловсролтой хүмүүс байна.


бүс	бүгд	боловсролгүй	бага	суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай дунд	Дээд
Улсын дүн	9596	215	1020	3523	3441	485	289	623
Баруун бүс	3597	81	446	1309	1245	143	120	253
Баян-Өлгий	137	3	29	33	53	6	4	9
Говь-Алтай	1674	34	206	614	600	54	55	111
Завхан	426	10	39	130	141	24	18	64
Увс	539	18	83	185	181	30	19	23
Ховд	821	16	89	347	270	29	24	46

Өмнөх судалгаанд оролцогчдын 7.8 хувь нь боловсролгүй, 23.7 хувь нь бага, 31.1 хувь нь суурь, 29.7 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь техник мэргэжлийн болон тусгай дунд, дээд боловсролтой хүмүүс байлаа.

Судалгаанд хамрагдсан 539 иргэдийн 372 буюу 69 хувь нь мэргэжилгүй, 1 буюу 0.2 хувь нь менежер, 24 буюу 4.5 нь мэргэжилтэн, 10 буюу 1.8 хувь нь техникч, 2 буюу 0.4 хувь нь контор үйлчилгээний ажилтан, 9 буюу 1.7 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан, 13 буюу 2.4 хувь нь хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, 46 буюу 8.5 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан, 60 буюу 11.1 хувь нь машин механизмын оператор, угсрагч, 2 буюу 0.4 хувь нь энгийн ажил мэргэжлийн хүмүүс байна.

Эзэмшсэн мэргэжлийг бүсээр авч үзвэл мэргэжилгүй иргэдийн 38.1 хувь нь Баруун бүсэд, 32.7 хувь нь Төвийн бүсэд, 15.8 хувь нь Хангайн бүсэд, 10.9 хувь нь Улаанбаатарт, 2.4 хувь нь Зүүн бүсэд, харин машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагчийн мэргэжилтэй бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 44.1 хувь нь Төвийн бүсэд, 26.2 хувь нь Баруун бүсэд, 22.3 хувь нь Улаанбаатарт, 6.6 хувь нь Хангайн бүсэд, 0.8 хувь нь Зүүн бүсэд байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчид эзэмшсэн мэргэжлээр, хувь




Бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийг авч үзвэл 70.7 хувь нь 1-5 ам бүлтэй, 28.7 хувь нь 6-9 ам бүлтэй, 0.6 хувь нь 10-с дээш ам бүлтэй байна. Ам бүлийн дундаж тоо Баруун бүсэд өндөр, улсын дунджаас 1 хүнээр илүү байна.

Ашигт малтмалын илрэл бүхий нийт 113 /бичил уурхайн зориулалтаар дүгнэлт гаргасан/ орд газрын 332 цэг, аманд бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаагийн 205 буюу 61.7 хувь нь 4 аймаг 1 дүүрэгт байршиж тэдгээрээс Налайхад 88, Баянхонгорт 37, Төв аймагт 29, Өмнөговьд 29, Говь-Алтайд 22 нь байршиж байна.

Нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо улсын дунджаар 29 байгаа бөгөөд аймаг нийслэлээр авч үзвэл Дундговьд 83, Говь-Алтайд 76, Завханд 71, Сэлэнгэд 56, Ховдод 46, Увсад 45, Өмнөговьд 34, Архангайд 32, Говьсүмбэрт 30 ногдож бусад аймаг нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор улсын дунджаас нягтаршил ихтэй байна.

Зураг 3. Нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо, аймгуудаар




Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор ул уурхайн салбарын голлох нэр төрөл болох алт, нүүрсний илрэл бүхий орд газар ихтэй Баянхонгор, Төв, Увс, Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймгууд тэргүүлж байна. Харин жону, гянтболд зэрэг ашигт малтмалын орд газартай Зүүн бүсийн аймгууд доогуур байранд орж байна. Үүнээс харахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын төвлөрөл нь ашигт малтмалын төрлөөс шууд хамааралтай байна.

#### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Судалгаанд хамрагдсан иргэдийн 0.7 хувь нь хоршооны ахлагч, гишүүн, 7.1 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 5.6 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 41.6 хувь нь нөхөрлөлийн ахлагч, гишүүн, 45.0 хувь нь хувиараа /дангаараа/ ашигт малтмал олборлогч иргэд байна.

Зураг 4. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо, ажил эрхлэлтийн төрлөөр




### Нөхөрлөлийн ахлагч гишүүн:

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 7.6 хувь нь нөхөрлөлийн ахлагч, 33.9 хувь нь нөхөрлөлийн гишүүн байна. Нөхөрлөлийн орлого хувиарлалтыг авч үзвэл 186 буюу 83 хувь нь орлогоо тэнцүү хувиарладаг, 35 буюу 15.6 хувь нь орлогоо хийснээр нь хувиарладаг, 1 буюу 0.4 хувь нь орлого хувиарладаггүй, 2 буюу 0.9 хувь нь тогтмол цалинждаг байна. Нөхөрлөлийн орлого хувиарлалтыг бүсээр авч үзвэл Төвийн бүсийн 46.3 хувь нь, Баруун бүсийн 41.4 хувь нь Хангайн бүсийн 10.8 хувь нь бичил уурхайгаас олсон орлогоо гишүүддээ тэнцүү хувиарладаг байна.

### Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа, шалтгаан

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 55 буюу 13.1 хувь нь нэг хүртлэх жил, 99 буюу 23.6 хувь нь 2-3 жил, 70 буюу 16.7 хувь нь 4-5 жил, 64 буюу 15.2 хувь нь 6-7 жил, 25 буюу 5.9 хувь нь 8-9 жил, 55 буюу 13.1 хувь нь 10-11 жил, 52 буюу 12.4 хувь нь 12-оос дээш жил ажилласан байна. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 36.7 хувь нь 3 хүртэлх жил ажилласан байгаа нь сүүлийн 3 жил иргэд бичил уурхайн салбарт шинээр татагдан орж ирж байгааг харуулж байна.

Зураг 5. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, хувиар, бичил уурхайн эрхэлж буй шалтгаанаар




Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг ямар шалтгаанаар уг үйл ажиллагааг эрхэлж байгааг судалж үзэхэд 53.5 хувь нь ажлын байр олдоогүйгээс, 23.1 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 7.9 хувь нь малгүй болсон учраас, 15.4 хувь нь өөрийн бизнесээ болгох болон бусад зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УС

Судалгаанд хамрагдсан бичил уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид бүгд орд газраа байрлаж ямар нэгэн сууцанд амьдардаг гэж хариулсан ба эдгээрийн 260 буюу 84.1 хувь нь гэрт, 3 буюу 1 хувь нь байшинд, 9 буюу 2.9 хувь нь майханд, 19 буюу 6.1 хувь нь түр оромжинд, 11 буюу 3.6 хувь нь нүхэн сууцанд, 7 буюу 2.3 хувь нь бусад сууцанд амьдардаг гэж хариулсан байна

Цахилгааны эх үүсвэр нь бичил уурхай эрхлэгчдийн ая тухтай ажиллаж, амьдрах нэг чухал үзүүлэлт бөгөөд үүнтэй холбоотойгоор уйл ажиллагаа явуулж буй газрынх нь цахилгааны эх үүсвэрийн мэдээллийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэж ангилан судаллаа. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 56 хувь нь цахилгааны эх үүсвэртэй гэж хариулсны 111 нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, 59 нь бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг байна.

Зураг 6. Бичил уурхай эрхлэгчдийн цахилгаан эх үүсвэр



Өмнөх судалгаанд оролцогчдын 61 хувь нь цахилгааны эх үүсвэртэй гэж хариулсан байлаа.

Бичил уурхай эрхлэгчдийн ундны усны эх үүсвэрийг судлахад 82 нь зөөврийн ус, 323 нь гол мөрний усаар бусад нь бусад эх үүсвэрээс /ус түгээх байр, цэвэршүүлсэн савласан ус гэх мэт/ ундны хэрэгцээгээ хангаж байна.


### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Уг судалгаанд бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийн эрх ашиг, бэртэл гэмтэл, бичил уурхайд гүйцэтгэж буй үүргийн талаар судалсан .



Судалгаанд оролцогч иргэдийн хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг авч үзвэл 105 буюу 25 хувь нь сайн, 183 буюу 44 хувь нь дунд, 76 буюу 18 хувь нь муу, 56 буюу 13 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 7. Хүүхдийн эрхийн мэдлэгийн талаар



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч хүүхдүүд улирлын амралт, хичээлийн бус цагаар ус чулуу, шороо зөөх, нүх ухах, алт, чулуу угаах болон бусад туслах үйл ажиллагаанд оролцдог байна.

### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 94.3 хувь нь буюу 396 иргэн гар утас ашигладаг байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хууль эрх зүй, дүрэм журам болон өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хомсдолтойгоос үүдэн өөрсдийн болон байгаль орчноо хохироох тохиолдол нэлээдгүй гардаг. Тэдэнд хамгийн их хэрэгцээтэй мэдээллийг төрлөөр авч үзвэл давхардсан тоогоор 23.3 хувь нь нийгмийн халамж, эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар, 22.7 хувь нь бичил уурхайн талаар, 11.6 хувь нь өдөр тутмын мэдээллийн талаар, 15.9 хувь нь хууль эрх зүйн, 13.5 хувь нь нөхөн сэргээлт, байгаль орчны талаарх мэдээлэл байгаа бол 13.0 хувь нь бусад /улс төр, боловсрол, соёл, шинжлэх ухаан, гэр бүл хүүхдийн асуудал г.м/ төрлийн мэдээлэл гэж хариулжээ.

Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хууль эрх зүйн орчин, дүрэм журам болон байгаль орчны асуудлын талаарх мэдээлэл түлхүү хэрэгцээтэй байна. Бичил уурхай эрхлэгчдийн мэдээллийн эх үүсвэрийг авч үзэхэд 39.8 хувийг телевизээс, 17.1 хувийг бусад иргэдээс, 13.5 хувийг хурал, цуглаанаас, 7.5 хувийг гар утсаараа дамжуулан, 3.2 хувийг радиогоос, 3.6 хувийг хэвлэмэл тараах материалаас, 4.2 хувийг мэдээллийн самбараас, 11.1 хувийг бусад эх үүсвэрээс авдаг байна.


Бичил уурхай эрхлэгчдийн хамгийн гол мэдээллийн эх үүсвэр нь телевиз байна. Насны бүлгээр авч үзвэл телевиз болон гар утсаараа дамжуулан 30-34 насныхан, радио болон бусад иргэдээс 35-39 насныхан, интернет, нийгмийн сүлжээнээс 25-29 насныхан, мэдээллийн самбар, хэвлэмэл тараах материал, сонин сэтгүүл болон хурал цуглаанаас 40-44 насныхан хамгийн их мэдээлэл олж авдаг байна.

## БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН МЭДЛЭГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс мөн энэ талаарх мэдлэг багатайгаас үүдэн осол аваарт өртөх явдал тохиолддог. Тэдний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийн түвшнийг авч үзвэл 16.4 хувь нь хангалттай мэдлэгтэй, 58.6 хувь нь зохих хэмжээний мэдлэгтэй, 25 хувь нь хангалтгүй мэдлэгтэй гэж өөрсдийгөө үнэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч 411 хүний 14 нь үйлдвэрлэлийн осол аваарт өртөж байсан байна. Тэдний 21.1 хувь нь агааргүйдэх, 26.3 хувь нь шороонд дарагдах, 5.3 хувь нь хөлдөх, 15.8 хувь нь нүхэнд унах, 31.6 нь бусад осолд өртөж байсан байна.

Зураг 8. Бичил уурхай эрхлэгчдийн осол аваарт өртсөн эсэх




Өмнөх судалгаанд оролцогчдоос 33 нь осол аваарт өртөж байсны 22.9 хувь нь агааргүйдэх, 25 хувь нь шороонд дарагдах, 10.4 нь хөлдөх, 41.7 хувь нь нүхэнд унах зэрэг осолд өртөж байсан байжээ.

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлэгчдийн 95.1 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн өвчин тусч байгаагүй бол 4.9 хувь нь ямар нэгэн өвчин эмгэг тусч байжээ. Бичил уурхай эрхлэх явцдаа өвчин туссан иргэдийн 18 хувь нь амьсгалын тогтолцооны, 18 хувь нь ууц нурууны, 14 хувь нь хоол боловсруулах замын, 14 хувь нь зүрх судасны

тогтолцооны, 14 хувь нь шээс бэлгийн замын өвчнөөр, 11 хувь нь яс булчингийн тогтолцооны, 4 хувь нь арьсны, 7 хувь нь халдварт өвчний эмгэгээр өвчилж байсан байна. Өмнөх судалгаанд оролцогчдын 77.9 хувь нь ууц нурууны, 17.3 хувь нь амьсгалын тогтолцооны өвчнөөр бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчилж байжээ.

*Эндээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орчин болон ажлын онцлогоос хамаарч бичил уурхай эрхлэгчдийн ихэнх хувь нь амьсгалын тогтолцооны болон ууц нурууны өвчнөөр өвчилдөг байна.*

Зураг 9 . Бичил уурхай эрхлэгчдийн өвчлөлийн талаар



Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдээс эмнэлгийн тусламж авах боломжийн талаар асуухад ихэнх нь үйл ажиллагаа эрхэлж буй сум дүүргийнхээ эмнэлгээс тусламж авах боломжтой гэж хариулсан бол хамгийн ойр эмнэлэг 2 км хамгийн хол нь 190 км-т оршиж байна.

### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР


Бичил уурхай эрхлэгчдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлснээр тэдний амьдралд гарсан өөрчлөлт, төрийн болон ТББ-с тэдэнд үзүүлсэн дэмжлэг, туслалцааны талаар авч үзсэн. Судалгаанд хамрагдсан иргэдийн 228 буюу 55.5 хувь нь даатгалд хамрагдаагүй, 44.5 хувь буюу 183 нь даатгалд хамрагдсан байна. Үүнээс давхардсан тоогоор 111 нь нийгмийн даатгалд, 166 нь эрүүл мэндийн даатгалд хамрагддаг ажээ. Өмнөх судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь ямар нэгэн даатгалд хамрагддаг байснаас үзэхэд энэ судалгааны дүнгээр даатгалд хамрагддаг иргэдийн тоо буурсан байна.

Бичил уурхай эрхэлснээр давхардсан тоогоор 437 хүний амьжиргаанд нь сайнаар өөрчлөлт орсон байна.



Бичил уурхай эрхлэгчдээс орон нутагтаа хэр хувь нэмэр оруулсныг асуухад 65 хувь нь хувь нэмэр оруулаагүй, 35 хувь нь ямар нэгэн хувь нэмэр оруулсан байна.

Зураг 10. Зураг Бичил уурхай эрхлэгчдийн орон нутагт оруулсан хувь нэмэр



Өмнөх судалгаанд оролцогчдын 77.5 хувь нь орон нутагтаа ямар нэгэн хувь нэмэр оруулж байгаагүй, 22.4 хувь нь хувь нэмэр оруулж байснаас харахад энэ судалгааны дүнгээр хувь нэмэр оруулагчдын тоо өссөн байна.

### БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ АВСАН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан авсан тусламж дэмжлэг болон тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэж буй талаар авч үзсэн. Бичил уурхай эрхлэгчдийн 82.7 хувь нь ямар нэгэн тусламж дэмжлэг аваагүй, 17.3 хувь нь авч байсан гэж хариулсан байна. Өмнөх судалгаанд оролцогчдын 9.8 хувь нь тусламж дэмжлэг авч байснаас үзэхэд энэ судалгаанд оролцогчдоос дэмжлэг тусламж авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Мөн 167 хүнд хүндрэл бэрхшээл тулгарч байгаагүй бол 247-д нь хүндрэл бэрхшээл тулгарч байжээ. Эдгээр хүмүүсийн 15.9 хувь нь хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй, 25.1 хувь нь ашигт малтмалын гарц бага, 21.5 хувь нь үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал, 7.3 хувь нь санхүүгийн асуудлаа шийдэх

зээл авахад хүндрэлтэй, 12.5 хувь нь хяналт шалгалт дарамт ихтэй, 5.1 хувь нь зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй гэж хариулсан байна.

Харин өмнөх судалгаанд оролцогчдын 57.5 хувьд нь хүндрэл бэрхшээл тулгарч байсан гэж хариулсны 14.6 хувь хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй , 19.6 хувь нь ашигт малтмалын гарц бага, 18.2 хувь нь үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал, 4.6 хувь нь санхүүгийн асуудлаа шийдэх зээл авахад хүндрэлтэй, 17.5 хувь нь хяналт шалгалт дарамт ихтэй, 10.4 хувь нь зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй гэж хариулсан байна.

Судалгааны дүнгээр бичил уурхай эрхлэгчдийн 35.5 хувь нь засаг захиргааны байгууллагатай харьцахад хүндрэлтэй, 64.5 хувь нь хүндрэлгүй гэж хариулжээ. Давхардсан тоогоор 128 хүн орон нутгийн засаг захиргааны байгууллагыг , 35 хүн байгаль орчны байгууллагыг, 49 хүн мэргэжлийн хяналтын байгууллагыг, 48 хүн хууль хяналтын байгууллагыг, 32 хүн ашигт малтмалын газрыг, 29 хүн татварын байгууллагыг, 11 хүн эрүүл мэндийн байгууллагыг харьцахад хүндрэлтэй гэж тодорхойлжээ.

Бичил уурхай эрхлэгчдийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэсэн байдлыг асуухад засаг захиргааны байгууллагатай харьцахад хүндэртэй иргэдийн 6 нь асуудлаа шийдвэрлэсэн бусад нь шийдвэрлээгүй байна. Олборлосон ашигт малтмалаа борлуулахад гардаг хүндрэл бэрхшээлийн талаар судлахад 382 нь ченжүүд газар дээр нь аваад хүндрэлгүй гэсэн бол 29 нь орон нутагт албан ёсны худалдан авах цэг байхгүй, сорьцын газар байхгүй, ченжүүд зах зээлийн үнээс доогуур авдаг, ханш тогтвортой бус зэрэг хүндрэл тохиолддог гэж хариулсан байв.

Ашигт малтмал олборлох газрынхаа асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар асуухад 13 нь сумын засаг дарга, ашигт малтмал эзэмшигчтэй гэрээ байгуулж, 6 нь бусдын талбайд гэрээгүй ажиллаж шийдвэрлэсэн гэжээ.

Судалгаагаар бичил уурхай эрхлэгчдээс төрийн болон ТББ-с ямар тусламж дэмжлэг авахыг хүсдэг талаар асуухад давхардсан тоогоор дараахь байдлаар хариулсан байна.



## БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНИК ТОНОГ , ТӨХӨӨРӨМЖ

Бичил уурхай эрхлэгчид өөрийн болон түрээсийн, хамтын эзэмшлийн 2750 ширхэг тоног төхөөрөмжийг ашигладаг байна.

	гар багаж /алх,жоотуу, хүрээ/	металл хайгч	цахилгаан үүсгүүр	агааржуу лагч	цохилтот өрөм	өргөх төхөөрөмж	трос	усан буу	насос	бага оврын цохилтот өрөм	бусад
ТТ тоо	1392	138	178	82	183	179	172	143	114	60	109

Бичил уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн 50.6 хувь нь гар багаж , 5 хувь нь металл хайгч, 6.5 хувь нь цахилгаан үүсгүүр, 6.6 хувь нь цохилтот өрөм, 6.5 хувь нь өргөх төхөөрөмж, 6.2 хувь нь трос, 5.2 хувь нь усан буу, 3.1 хувь нь агааржуулагч, 4.1 хувь нь ус татах насос үлдэх хувь нь бусад тоног төхөөрөмжүүд байна.

Бичил уурхай эрхлэгчдийн 77.1 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг бол 22.9 хувь нь хэрэглэдэггүй гэж хариулсан байна.

## БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцогчдын 368 буюу 87.6 хувь нь алт олборлогч, 35 буюу 8.3 хувь нь нүүрс олборлогч, 17 буюу 4 хувь нь бусад /давс/ ашигт малтмал олборлогч иргэд байлаа. Өмнөх судалгаанд оролцогчдын 93 хувь нь алт олборлогч, 4.3 хувь нь нүүрс олборлогч, 2.7 хувь нь давс олборлогч иргэд байв.

Зураг 11. Бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын төрөл



Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй газрын зөвшөөрөл, талбайн хэмжээ, эвдрэл, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг судалсан.

362 буюу 88.1 хувь нь зөвшөөрөлгүй талбайд. 49 буюу 11.9 хувь нь зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхэлж байна. Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа иргэдийн 19 нь орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт, 30 нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газарт тус тус үйл ажиллагаа явуулж байна. Тэднээс нөхөн сэргээлт хийсэн эсэхийг асуухад 82 хувь нь хийгээгүй, 18 хувь нь хийсэн гэж


хариулсан байна. Өмнөх судалгаанд оролцогчдын 5.2 хувь нь нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Судалгаанд оролцогчид 2016 онд 10149.9 грамм алт, 723.3 тонн нүүрс, 65.8 тонн бусад ашигт малтмал олборлосон бол өмнөх судалгаанд оролцогчид 32.3 кг алт, 815.5 тн нүүрс, 1051.6 тн давс олборлож байсан байна.

Судалгаанд хамрагдсан алт олборлогчдын 44.5 хувь нь Баруун бүсэд ноогдож тэд 62.5 кг алт олборлож 1 грамм алтыг дунджаар 67.7 мянган төгрөгөөр борлуулсан байна. Алтны дундаж үнэ Увс аймагт улсын дунджаас 0.6 мянган төгрөгөөр бага байлаа.


Бичил уурхай эрхлэгчдээс татвар төлдөг эсэхийг асуухад 80.3 хувь буюу 330 нь үгүй, 19.7 хувь буюу 81 нь тийм гэж хариулсан байна. Татвар төлсөн иргэд 8.5 сая төгрөгийн татварыг төлсөн байна.

Татвар төлсөн хэмжээг харвал: /сая.төг, татварын төрлөөр/



Өмнөх судалгаанд оролцогчдын 35.2 хувь нь 10.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулж байжээ. Үүнээс харахад бичил уурхай эрхлэгчдийн татвар төлөлтийг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Судалгаанд оролцогчид олборлосон ашигт малтмалаасаа 772.8 сая төгрөгийн орлого олж 559.8 сая төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн байна.



Нэмэгдэл өртгийн 95 хувь нь ашиг, 3.0 хувь нь цалин хөлс ажилчдад өгсөн тусламж, 0.4 хувь нь зээлийн хүүгийн зардал үлдэх хувь нь татвар, төлбөр хураамжийн зардлууд байна.

*Өмнөх судалгаанд оролцогчдын орлогынх нь 86.8 хувийг нэмэгдэл өртгийн зардлууд эзэлж байсан бол энэ удаагийн судалгаанд оролцогчдын 72.4 хувийг нэмэгдэл өртгийн зардал эзэлж байгаа нь бичил уурхай эрхлэгчдийн үйлдвэрлэх нэмэгдэл өртөгт /цалин, ашиг, татвар г.м/ анхаарах хэрэгтэй байна.*

Судалгаанд оролцогч бичил уурхай эрхлэгчдийн 7.5 хувь нь 45.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үүний 32.9 сая төгрөгийг тээврийн хэрэгсэлд, 10.9 сая төгрөгийг тоног төхөөрөмжинд, 1.2 сая төгрөгийг бусад зүйлд хөрөнгө оруулсан байна.

### **МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ТУХАЙ**

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах, шалгах, засварлах Мэдээллийг компьютерт оруулах CSPRO програм хангамжийг анализ, дүн шинжилгээг статистикийн шинжилгээний SPSS програм хангамжийг ашиглан боловсруулсан. Судалгааны үр дүнгийн 120 гаруй хүснэгт боловсруулж гаргасан эдгээрийг Ашигт малтмалын газрын тосны газрын бичил уурхай эрхлэгчдийн холбогдох мэдээлэл, Монгол улсын эрдэнэсийн санд худалдсан алтны мэдээ, Стандартчилал хэмжил зүйн газрын Улсын сорьцын хяналтын хэлтсийн лабораториор сорьц тогтоолгосон алтны мэдээ, ТЕГ-ын бичил уурхай эрхлэгч иргэдийн төлсөн татварын мэдээ, ҮСХ-ны нийгэм эдийн засгийн судалгааны үр дүн, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэрүүдтэй үр дүнг тулгаж шалгасан.



## ҮР ДҮН:

Манай улсын болон аймгийн эдийн засагт зохих байр эзэлдэг уул уурхай, олборлох салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн дүр төрх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлсэн.

Ашигт малтмал олборлож буй иргэдийн 87.6 хувь, орлогын 88.9 хувь, нэмэгдэл өртгийн 87.0 хувийг алт олборлолтын үйл ажиллагаа бүрдүүлж байгаа нь алт олборлодог иргэд олон гэдгийг харуулж байна.

Монгол улсын Засгийн газар бичил уурхайн салбарыг төрөөс зохицуулах, энэ салбарыг үндэсний эдийн засгийг бүрдүүлэгч идэвхтэй хэсэг болгох талаар явуулж буй арга хэмжээний хүрээнд бичил уурхайд чиглэсэн бодлого эрх зүйн таатай орчныг бий болгох, албан ёсны, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих үүднээс “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан. Энэ нь тус салбарт хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход түлхэц болсон бөгөөд энэхүү судалгааны үр дүнг үндэслэн орон нутагт бичил уурхай эрхлэгчдийн талаар бодлого боловсруулж, шийдвэр гаргахад үндсэн суурь мэдээлэл нь болох юм.